

209



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 91 оны 12 сарын 24

№ 360

Улаанбаатар хот

238 93 1/96 Захирал


Улсын үйлдвэрийн газар
байгуулах тухай.

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Хотын Иргэний Гэр Бүлийн Байдлыг Бүртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын оронг Улсын үйлдвэрийн газар " УҮГ " болгон өөрчлөн зохион байгуулж аж ахуйн бүрэн тооцон дээр ажиллуулсугай.

2. Хотын Иргэний Гэр Бүлийн Байдлыг Бүртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын ордон дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1990 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 295 дугаар тогтоолыг хүчингүй болгонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

Handwritten signature

Л.ЭНЭБИШ.

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Handwritten signature

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын хур-
лын гүйцэтгэх захиргааны
1991 оны 360 тоот тогтоолыг
хавсралт.

**УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДЛЫГ
БҮРТГЭХ ХЭЛТЭС, ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДНЫ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хотын Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын ордон нь Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны харьяа байгууллага мөн.

2. Тус хэлтэс, ордон нь БНМАУ-ын Гэр бүлийн хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан бусад зарлиг, тогтоол, зааврыг удирдлага болгон, иргэдийн гөрөлт, гэрлэлт, гэрлэлт сэргээлт, цуцлалт, үрчлэлт, овог нэр өөрчлөлт, эцэг тогтоолт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөнийг бүртгэхээс гадна хаяж үрэгдүүлсэн болон хүчингүй болгосон гэрчилгээ, баталгааг дахин олгох, бүртгэлд засвар оруулах үйлчилгээг эрхлэн явуулна.

3. Хэлтэс, ордон нь улсын өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж, үйл ажиллагаатай холбогдсон эрх эдлэн, үүрэг хүлээж, биеэ даасан харилцах данс, тэнцэтгэлтэй хуулийн этгээд болно.

4. Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын ордон нь тус тусдаа албан бичгийн болон гушаалын хэвлэмэл хуудас, /хэлтсийн хуудас сүлдтэй/ мөн тус бүр тамга, тэмдэг, албан бичгийн дардас /нуур/ хэрэглэнэ.

5. Тус хэлтэс, ордон нь өөрийн үйл ажиллагааг бие даасан байдлаар явуулж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаагаа эдийн засгийн арга, аж ахуйн бүрэн тооцооны үндсэн дээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэн, материал санхүүгийн нөөцийг хэмнэж, эдийн засгийн үр ашигтай ажиллах зарчмыг хэрэгжүүлэн ажиллана.

Хоёр. Хүлээх үүрэг, эдлэх эрх

1. БНМАУ-ын Гэр бүлийн хуулийн биелэлтэд хяналт тавьж, түүнийг хэрэгжүүлэн, хотын Ардын хурлын дэвсгэрт иргэний гэр бүлийн

байдлын бүртгэлийг чанартай, хөнгөн шуурхай, соёлтой бүртгэх, хөдөлмөр зохион байгуулалт, удирдлагыг боловсронгуй болгох.

2. Гэр бүлийн хууль тогтоомж, иргэний гэр бүлийн бүртгэлийг иргэдэд сурталчлан тайлбарлах, бүртгэлийг элдэв чирэгдэлгүй явуулах.

3. Бүртгэл явуулж, албан үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн иргэдийн гэр бүлийн аливаа харилцаа, бүртгэлийн явууцыг хадгалах.

4. Хотын харьяа дүүрэг болон хороодын Ардын хурлын гүйцэтгэх захиргаадаас хийж байгаа иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хянаж, мэдээ талланг улирал, хугас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж мэдээлэх.

5. Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаанаас баталсан ажил, үйлчилгээний үнэ тарифыг мөрдөж, ордны дагалдах төлбөрт үйлчилгээний үнийг өөрөө тогтооно.

Зарим ядуу амьдралтай, өнчин зэрэг амьдралын онц гачигдалтай иргэдийг үйлчилгээний үнээс чөлөөлөх асуудлыг хэлтсийн дарга, ордны захиргаа зохицуулан шийдвэрлэх эрх эдэлнэ.

6. Үйлчилгээ явуулах шаардлагатай уялдуулан үйлдвэр худалдааны болон бусад байгууллага, иргэд, хоршоо, компанитай аж ахуйн гэрээ, хэлцэл байгуулах, барааны бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулах эрхтэй.

7. Гадаадын байгууллагуудтай гэрээ, хэлцэл хийж, харилцаа тогтоох, холбогдох хүмүүсийг гадаад томилон явуулах.

8. Хэлтэс, ордны бүртгэлийн ажилтнууд иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх журам, зааврыг зөрчсөн хүмүүст хууль тогтоомжид заасны дагуу торгууль оногдуулах, бүртгэлд шаардагдах мэдээ, баримт бичиг, тодорхойлолт, магадлагааг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах эрхтэй. Мөн гарган өгөх эрхтэй болно.

9. Хэлтэс, ордон нь улсын банкнаас зээл авах, харилцах данс нээх, бараа материалыг худалдан авах, худалдах, хуулийн байгууллагад нэхэмжлэл гаргах эрх эдэлнэ.

10. Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө, эд хогшил худалдан авах, барьж байгуулах, эдэлгээний хугацаа дууссан хогшилыг худалдан зарцуулах асуудлыг бие даан шийдвэрлэнэ.

11. Өөрийн ажил, үйлчилгээний орлогоос олсон ашгаа хууль тогтоомж, өөрийн гаргасан зааврын дагуу ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ хүрээг өргөтгөхөд зориулна.

Гурав. Улирлага

1. Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс, Гэрлэх ёслолын ордны даргыг Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр томилно.

2. Хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаанд байгууллагын дарга хийсэн үйл ажиллагаагаа хариуцан тайлагнана.

3. Хэлтэс, ордны дарга нь ажилтнуудыг ажилд авах, чөлөөлөх, чөлөө олгох, шагнаж урамшуулах, шийтгэж хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлтэс, ордны даргын тушаалаар шийдвэрлэнэ.

4. Хэлтэс, ордны дарга байгууллагаа төлөөлж бусад газар, байгууллага, иргэд, хоршоо, компанитай хууль тогтоомжийн дагуу харилцах, гэрээ байгуулах, итгэмжлэх олгох, банкинд харилцах данс нээх, өөрийн үйл ажиллагааны хүрээнд тушаал заавар, дүрэм гаргах, эд хөрөнгийг захиран зарцуулах эрх эдэлнэ.

5. Хамт олны нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх, Захиргаанаас шийдвэрлэж чадаагүй буюу боломжгүй асуудлыг хамт олны хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.